

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн хууль тогтоомж

2.1.Мал, амьтны эрүүл мэндийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуултай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль мал, амьтны өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, өвчингүй, тайван улс, бүс, нутаг, хот айл, аж ахуйн нэгжийг тогтоон баталгаажуулах үйл ажиллагаа, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг, лабораторийн шинжилгээ, мал эмнэлэг, хорио цээр, хязгаарлалтын хяналт, шалгалттай холбогдох харилцаанд үйлчилнэ.

3.2.Зэрлэг амьтнаас мал, тэжээвэр амьтанд дамжин халдвартладаг халдварт өвчнийг тандах арга хэмжээнд үйлчилнэ.

3.3.Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."мал" гэж уламжлагдан маллаж ирсэн таван хошуу малыг;

4.1.2."тэжээвэр амьтан" гэж ашиг шимийг нь ашиглах болон бусад хэрэгцээнд зориулан гэршүүлэн үржүүлж байгаа амьтныг;

4.1.3."зэрлэг амьтан" гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.4-т заасан, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т зааснаас бусад амьтныг;

4.1.4."мэдрэмтгий мал, амьтан" гэж тодорхой нэрийн халдварт өвчинөөр өвчлөх эрсдэлтэй мал, амьтныг;

4.1.5."мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах" гэж мал, амьтны өвчинөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх, бүс, нутгийн халдварт өвчингүй, тайван байдлыг баталгаажуулах цогц үйл ажиллагааг;

4.1.6."халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх" гэж өвчиний гаралт, тархалтад нөлөөлж байгаа хүчин зүйлийг арилгах зорилгоор хийгдэх үзлэг, тандалт, халдвартгүйтгэл, дархлаажуулалт, нүүлгэн шилжүүлэлт, шилжилт хөдөлгөөний хяналт зэрэг мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.7."мал, амьтны өвчинтэй тэмцэх" гэж халдварт өвчинийг тандах, оношлох, халдварын эх үүсвэрийг илрүүлэх, тархалтын хүрээг тогтоох, дархлаажуулах, эмчлэх, шилжилт хөдөлгөөнийг хянах, мал эмнэлгийн хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх, өвчиний тархалтыг зогсоох, халдварталтын түвшинг бууруулах, устгах, өвчиний мэдээллийн сан бүрдүүлж ашиглах чиглэлээр хэрэгжүүлж байгаа мал эмнэлгийн цогц арга хэмжээг;

4.1.8."мал эмнэлгийн үйлчилгээ" гэж мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр мал эмнэлгийн мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг;

4.1.9."мал, амьтны гоц халдварт өвчин" гэж улсын хил хязгаараас үл хамааран богино хугацаанд тархаж, хүн, мал, амьтны эрүүл мэндэд хохирол учруулж, худалдаа, эдийн засгийн байдалд сэргээр нөлөөлөх өвчинийг;

4.1.10."шинэ болон дахин сэргэж байгаа өвчин" гэж Монгол Улсад анх удаа оношлогдож байгаа, эсхүл тухайн өвчинөөр тайван, эрүүл байгааг эрх бүхий байгууллагаас баталгаажуулсны дараа дахин гарч байгаа халдварт өвчинийг;

4.1.11."мал, амьтныг зайлшгүй шаардлагаар төхөөрөх" гэж өвчтэй болон халдварын голомтод байгаа халдвартараах нь тогтоогдсон мал, амьтныг холбогдох журам зааврын дагуу төхөөрөч, биологийн хаягдлыг устгахыг;

4.1.12."мал, амьтныг зайлшгүй шаардлагаар устгах" гэж өвчтэй болон халдвартын голомтод байгаа халдвартараах нь тогтоогдсон мал, амьтныг холбогдох журам, зааврын дагуу бүрэн устгахыг;

4.1.13."ийлдсийн сан" гэж халдварт өвчин үүсгэгчийн эсрэг бие махбодод үүссэн эсрэг биеийг илрүүлэх, үүсгэгчийн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл авах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгээс мал, тэжээвэр амьтны төрөл, нас, хүйсийг төлөөлүүлэн тодорхой тооны сорьц авч, жил бүр нөхөн сэлбэдэг цусны ийлдсийн цуглулгыг;

4.1.14."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэнийг;

4.1.15."амьтан маллагч" гэж амьтныг арчлах, тэжээх, болзошгүй аюулаас хамгаалах, хашаа, байр, нөмөр, хорго, хэвтрэйг цэвэрлэх үүрэгтэй иргэнийг;

4.1.16."тэжээлийн нэмэлт" гэж мал, амьтны бие махбодын үйл ажиллагааг дэмжих, зохицуулах үйлчилгээ бүхий дан болон олон найрлагат бэлдмэлийг.

5 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалахад баримтлах зарчим

5.1.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар дараах үндсэн зарчмыг баримтална:

5.1.1.мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, бие даасан, нэгдмэл байдлыг хангах;

5.1.2.мал эмнэлгийн үйлчилгээг энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан тэгш, хүртээмжтэй хүргэх;

5.1.3.нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны хориг саадыг арилгахад чиглэх;

5.1.4.үндэсний онцлог, уламжлалд тулгуурлан, олон улсын жишиг, чиг хандлагад нийцүүлэх;

5.1.5.төр, иргэн, хуулийн этгээдийн хамтын үйл ажиллагаанд тулгуурлах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МАЛ, АМЬТНЫ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

6 дугаар зүйл.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

6.1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ерөнхий ба тусгай хэлбэрээр зохион байгуулна.

6.2.Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ нь мал, амьтны бүх төрлийн өвчнөөс сэргийлэхэд чиглэгдэнэ.

6.3.Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээнд хашаа, байр, тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, ариун цэвэр, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдвартгүйтгэл, шилжилт хөдөлгөөний хяналт хамаарна.

6.4.Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээнд эрсдэл бүхий халдварт өвчний тархалтыг хязгаарлах, халдварталтын хувийг бууруулахад чиглэгдэх бөгөөд тархвар зүйн судалгаа, дархлаажуулалт, нүүлгэн шилжүүлэлт, шилжилт хөдөлгөөний хяналт хамаарна.

6.5.Зайлшгүй шаардлагаар хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээнд мал, амьтнаа тогтоосон хугацаанд хамруулаагүйгээс бусдад учирсан хохирол болон уг арга хэмжээг нөхөн хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлыг мал, амьтан өмчлөгч хариуцна.

6.6.Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг товлосон хугацаанд хэрэгжүүлээгүй, эсхүл мал эмнэлгийн үйлчилгээний заавар, стандартыг мөрдөж ажиллаагүйн улмаас бусдад учирсан хохирлыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хариуцна.

7 дугаар зүйл.Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг хэрэгжүүлэх

7.1.Малчин, амьтан маллагч нь мал, амьтан маллах, ашиглах, эдлэх, тээвэрлэхдээ хашаа, байр, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, ариун цэврийн нийтлэг зааврыг дагаж мөрднө.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

7.3.Орчны цэвэрлэгээ, ариутгал, халдвартгүйтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд доор дурдсан этгээд дараах үүргийг хүлээнэ:

7.3.1.мал, амьтан өмчлөгч малын эмчийн зааварчилгааны дагуу өвөлжөө, хаваржaa болон эрчимжсэн мал аж ахуйн байрны ойр орчимд мал, амьтны хүүр, сэг зэм, биологийн хаягдал устгах зориулалтын цгэ барьж ашиглах;

7.3.2.малчин, амьтан маллагч нь хашаа, байрны ойр орчимд болон ашиглаж байгаа бэлчээрт энэ хуулийн 7.3.3-т зааснаас бусад шалтгаанаар үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглувуулж устгах;

7.3.3.сум, дүүргийн Засаг дарга харьялах нутаг дэвсгэртээ гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглувуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах;

7.3.4.гудамж, талбай, цэцэрлэг болон нийтийн эзэмшлийн газар үхсэн мал, амьтны талаархи иргэн, байгууллагаас мэдээлэл хүлээн авсан харьялах хорооны Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж /цаашид "гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж" гэх/-тэй хамтран цэвэрлэгээ, халдвартгүйтгэл хийх, шаардлагатай үед сорьц авч лабораторид хүргүүлэх;

7.3.5.хот, суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан маллаж байгаа иргэн, хуулийн этгээд Эрүүл ахуйн тухай хуулийн 20.1.8-д заасан үүрэг хүлээх;

7.3.6.мал, амьтан үхсэн бол хашаа, байр, орчныг халдвартгүйтгэх ажлыг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж гүйцэтгэх.

7.4.Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.4.1.мал, амьтан өмчлөгч мал, амьтнаа яланг тэмдэглэж, бүртгэл хөтлөх;

7.4.2.нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, худалдах, төхөөрөх зорилгоор мал, амьтныг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гаргахдаа мал эмнэлгийн улсын байцаагчаас мал эмнэлгийн гэрчилгээ авч бүртгүүлэх;

7.4.3.өөр сум, дүүргийн нутаг дэвсгэрээс мал, амьтан шилжүүлэн авчрах бол мал эмнэлгийн тасагт урьдчилан мэдэгдэж, авчирсан даруй үзлэг хийлгэн тухайн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлэх.

7.5.Мал эмнэлгийн гэрчилгээ олгоходо гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянана:

7.5.1.халдварт өвчингүй, тайван бүс, нутагт маллаж байсан эсэх;

7.5.2.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай дархлаажуулалтад хамрагдсан эсэх;

7.5.3.тухайн мал, амьтанд халдварт өвчний ерөнхий болон өвөрмөц шинж тэмдэг илэрсэн эсэх;

7.5.4.хүнсэнд хэрэглэх мал, амьтанд эм хэрэглэснээс хойших хориглох хугацаа өнгөрсөн эсэх;

7.5.5.энэ хуулийн 7.4.1-д заасны дагуу яланг тэмдэглэгээ, бүртгэл хийгдсэн эсэх.

7.6.Энэ хуулийн 7.14, 7.15-д заасан хяналтын цэгт ажиллаж байгаа мал эмнэлгийн хяналтын цэгийн улсын байцаагч /цаашид "хяналтын цэгийн улсын байцаагч" гэх/ дараахь тохиолдолд дүгнэлт гаргаж, мал, амьтныг 14 хоногоос доошгүй хугацаанд хорио цээрийн хяналтад авна:

7.6.1.мал эмнэлгийн гэрчилгээ аваагүй;

7.6.2.халдварт өвчний сэжиг илэрсэн мал, амьтныг шилжилт хөдөлгөөний үед илрүүлсэн;

7.6.3.халдварт өвчингүй, тайван байдлыг баталгаажуулан зарласан бүс, нутагт нэвтрүүлэх тохиолдолд.

7.7.Энэ хуулийн 7.6-д заасан хугацаанд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.7.1.иргэн, хуулийн этгээд тээвэрлэж, тууварлаж, унаж, эдэлж явaa мал, амьтнаа мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын талбайд тусгайлан бэлтгэсэн хашаа, байранд оруулах;

7.7.2.хяналтын цэгийн улсын байцаагч эмнэл зүйн үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд сорьц авч холбогдох мал эмнэлгийн лабораторид хүргүүлэх;

7.7.3.сорьц хүлээн авсан лаборатори шинжилгээний дүгнэлтийг долоо хоногийн хугацаанд багтаан харьяалах хяналтын цэгт хүргүүлэх;

7.7.4.хяналтын цэгийн улсын байцаагч, сум, дүүргийн тархвар зүйч энэ хуулийн 7.5.1, 7.5.2-т заасан нөхцөлийг хангаж байгаа эсэхийг магадлах;

7.7.5.мал, амьтанд халдварт өвчин оношлогдоогүй бол хяналтын цэгийн улсын байцаагч мал эмнэлгийн гэрчилгээ олгож, хорио цээрийн хяналтыг цуцлах;

7.7.6.мал, амьтанд халдварт өвчин оношлогдсон бол энэ хуулийн 11.2-т заасан зааврын дагуу эмчлэх, төхөөрөх, эсхүл устгах;

7.7.7.мал, амьтныг тээвэрлэх, унаж эдлэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, хашлага, тоног хэрэгслийг халдвартгүйтгэх, өвс, тэжээлийн үлдэгдэл, дэвсгэр, чигжээс, биологийн хаягдлыг хяналтын цэгийн улсын байцаагчийн хяналт доор мэргэжлийн байгууллага устгах.

7.8.Энэ хуулийн 7.7-д заасан үйл ажиллагааны зардлыг мал, амьтныг тээвэрлэж, тууварлаж, унаж, эдэлж байгаа иргэн, хуулийн этгээд хариуцна.

7.9.Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам болон мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал тухуу тууврын замын чиглэлийг Засгийн газар батална.

7.10.Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

7.11.Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж бусад сум, дүүргийн нутаг дэвсгэрт оторлох мал сүрэгт эмнэл зүйн үзлэг хийж, энэ хуулийн 7.5.1-7.5.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар эрүүл мэндийн тодорхойлолт гаргана.

7.12.Мал, амьтны шилжилт хөдөлгөөнд дараахь үйл ажиллагааг хориглоно:

7.12.1.гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид урьдчилан мэдэгдэхгүйгээр бусад сум, дүүргээс мал, амьтан шилжүүлэн авах;

7.12.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын хамтарсан шийдвэрээр отор, эсхүл нүүлгэн шилжүүлэлт хийхээс бусад тохиолдолд энэ хуулийн 7.4.1-д заасан яланг тэмдэглэгээ, бүртгэл хийгдээгүй мал, амьтныг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс

гадагш тээвэрлэх, тууварлах, уналга, эдэлгээнд ашиглах;

7.12.3.мал, амьтныг хяналтын цэгт шалгуулахгүй өнгөрөх, эсхүл тогтоосон замаас өөр замаар тээвэрлэх, тууварлах, уналга, эдэлгээнд ашиглах;

7.12.4.энэ хуулийн 17.2, 18.3-т заасны дагуу хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон бус хооронд мал, амьтан тууварлах, тээвэрлэх.

7.13.Мал эмнэлгийн ариутгал, халдвартгүйтгэл хийх болон мал, амьтны хүүр, сэг зэм устгах зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

7.14.Халдварт өвчингүй, тайван бус, нутагт нэвтэрч байгаа улсын чанартай авто замыг түшиглэсэн байнгын ажиллагаатай мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийг Засгийн газрын шийдвэрээр байгуулна.

7.15.Нийслэлийн иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Засаг даргын шийдвэрээр түр, эсхүл байнгын ажиллагаатай мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг байгуулж болно.

7.16.Энэ хуулийн 7.15-д заасан хяналтын цэгийн үйл ажиллагааны зардлыг нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

8 дугаар зүйл.Тархвар зүйн судалгаа хийх, мэдээллийн сан бүрдүүлэх

8.1.Тархвар зүйн судалгааны хуудасны загвар, судалгаа хийх төлөвлөгөөг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан тархвар зүйн судалгааны хүрээнд сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг /цаашид "мал эмнэлгийн тасаг" гэх/ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

8.2.1.энэ хуулийн 8.1-д заасан хуудас ашиглан мэдээлэл цуглуулах;

8.2.2.шаардлагатай статистикийн мэдээллийг харьяалах нутгийн захиргааны байгууллагаас гаргуулан авах;

8.2.3.мал эмнэлгийн үзлэг, лабораторийн шинжилгээ хийлгэх ажил зохион байгуулах;

8.2.4.судалгааны дунд тулгуурлан сум, дүүргийн тархвар зүйн зураглал гаргах, холбогдох мэдээллийг халдварт өвчин гарсан үед өдөр тутам, халдварт өвчингүй, тайван үед энэ хуулийн 8.1-д заасан төлөвлөгөөний дагуу улирал тутам харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх.

8.3.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага халдварт өвчин гарсан үед мал эмнэлгийн тасгаас ирүүлсэн мэдээллийг тухай бүр, энэ хуулийн 8.1-д заасан төлөвлөгөөний дагуу ирүүлсэн улирал тутмын мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан тухайн нутаг дэвсгэрийн тархвар зүйн зураглал гаргаж, мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

8.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 8.3-т заасны дагуу хүлээн авсан мэдээллийг нэгтгэн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, улсын тархвар зүйн зураглал гаргана.

8.5.Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлгах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.6.Энэ хуулийн 8.4-т заасан мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталгаажуулахаас өмнө нийтэд мэдээлэх, бусдад дамжуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл.Дархлаажуулалтын ажил зохион байгуулах

9.1.Энэ хуулийн 6.4-т заасан дархлаажуулалтыг төлөвлөгөөт болон яаралтай хэлбэрээр зохион байгуулна.

9.2.Эрсдэл ихтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараа онд хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөө жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан энэ хуулийн 28.9-д заасан зөвлөлөөр хэлэлцүүлж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

9.3.Яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөөг тархвар зүйн судалгаа болон лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн гоц халдварт өвчний үед мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, бусад халдварт өвчний үед аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын дарга батална.

9.4.Дархлаажуулалтын товыг мал эмнэлгийн тасаг тогтоож, баг, хорооны Засаг дарга малчин, амьтан маллагчид зарлан мэдээлнэ.

9.5.Дархлаажуулалтыг гэрээт, эсхүл дайчлагдан ажиллаж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж холбогдох заавар, журмын дагуу хийнэ.

9.6.Дархлаажуулалтыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага болон мал эмнэлгийн тасаг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

9.7.Дархлаажуулалтын технологийн хяналтыг мал эмнэлгийн улсын байцаагч, үр дүнгийн хяналтыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори, шаардлагатай тохиолдолд улсын мал эмнэлгийн лаборатори хэрэгжүүлнэ.

9.8.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч дархлаажуулалт хийх үед дараах үүрэг хүлээнэ:

9.8.1.товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулах;

9.8.2. мал, амьтныг барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах.

9.9. Дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

10 дугаар зүйл.Халдварт өвчин гарсан үед мал, амьтныг нүүлгэн шилжүүлэх

10.1. Гоц халдварт өвчин гарсан үед мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын, бусад халдварт өвчин гарсан үед аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр энэ хуулийн 16.1.4-т заасан өвчингүй бүсэд байгаа мал, амьтныг нүүлгэн шилжүүлж болно.

10.2. Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нүүлгэн шилжүүлэх мал, амьтныг эмнэл зүйн үзлэгт нэг бүрчлэн хамруулж, сүргэгт эрүүл мэндийн тодорхойлолт гаргана.

10.3. Мал, амьтныг нүүлгэн шилжүүлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МАЛ, АМЬТНЫ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ

11 дүгээр зүйл.Мал, амьтны халдварт өвчний жагсаалт батлах

11.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт оношлогдсон мал, амьтны гоц халдварт, халдварт өвчиний жагсаалтыг доор дурдсан ангиллаар Засгийн газар батална:

11.1.1. мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин, хүний амь нас хохирох эрсдэл үүсгэдэг зооноз өвчин;

11.1.2. мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин, энэ хуулийн 11.1.1-д зааснаас бусад зооноз өвчин;

11.1.3. бусад халдварт өвчин.

11.2. Энэ хуулийн 11.1-д заасан халдварт өвчиний оношлох, мэдээлэх, тэмцэх зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өвчин тус бүрээр батална.

12 дугаар зүйл.Халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээ

12.1. Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ улс, бүс, нутгаар хязгаарлалт тогтоох бодлого баримтална.

12.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

12.3. Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хяналтад авах төлөвлөгөө, халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13 дугаар зүйл.Бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх

13.1. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын улсын төлөвлөгөөг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага халдварт өвчиний онош батлагдсан даруйд бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу мал эмнэлгийн бүх шатны байгууллагыг мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хяналт тавьж ажиллана.

13.3. Бэлэн байдлын төлөвлөгөөнд доор дурдсан арга хэмжээг тусгана:

13.3.1. удирдлага, зохион байгуулалт, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зарлан мэдээлэх;

13.3.2. санхүүжилтийн хэлбэр, санхүүгийн нөөц;

13.3.3. үзлэг, оношилгоо, тархвар зүйн судалгаа, дархлаажуулалт;

13.3.4. хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний хяналт, хорио цээр, хязгаарлалтын дэглэм;

13.3.5. устгал, нөхөн төлбөр, цэвэрлэгээ, ариутгал, халдвартгүйтгэл;

13.3.6. нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаа.

13.4. Улсын бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгайлан заасан бол аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга харьялах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх бэлэн байдлын дэд төлөвлөгөөг батална.

13.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн бэлэн байдлын дэд төлөвлөгөө боловсруулах аргачлалыг мал, амьтны эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.

13.6.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх үед дайчлах зориулалт бүхий нөөцтэй байна.

13.7.Энэ хуулийн 13.6-д заасан нөөцөд яаралтай дуудлага, шуурхай үйлчилгээнд зарцуулах тусгай зориулалтын төсөв, тоноглол бүхий автомашин, эм, халдвартгүйтгэлийн бодис, тоног төхөөрөмж, халдварт хамгааллын болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, шуурхай ажиллагаанд дайчлагдан ажиллах мэргэжлийн баг хамаарна.

13.8.Энэ хуулийн 13.6-д заасан нөөцийг бүрдүүлэх, зарцуулахдаа Улсын нөөцийн тухай хуулийн 13.1.9-д заасан журмыг баримтална.

13.9.Энэ хуулийн 28.1-д заасан хуулийн этгээд мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгах шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх өдөр тутмын бэлэн байдалд ажиллана.

14 дүгээр зүйл.Халдварт өвчнийг тандах, өвчингүй, тайван байдлыг баталгаажуулах

14.1.Улсын хэмжээнд халдварт өвчнийг тандах төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сард багтаан энэ хуулийн 28.9-д заасан мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.

14.2.Мал, амьтны халдварт өвчнийг тандах, үр дүнг мэдээлэх болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг урамшуулах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

14.3.Энэ хуулийн 14.1-д заасан төлөвлөгөөг мал эмнэлгийн сүлжээ лаборатори, мал эмнэлгийн тасагтай хамтран хэрэгжүүлнэ.

14.4.Малчин, амьтан маллагч мал, амьтнаас сорьц авах үед энэ хуулийн 9.8-д заасан үүрэг хүлээнэ.

14.5.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори иргэн, хуулийн этгээдийн захиалгаар тухайн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа мал, амьтанд халдварт өвчингүй, тайван байдлыг баталгаажуулах шинжилгээ хийж болно.

14.6.Энэ хуулийн 14.1-д заасан төлөвлөгөө, 14.5-д заасан шинжилгээний дүнг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн халдварт өвчингүй, тайван улс, бус, нутгийн талаар нийтэд мэдээлнэ.

14.7.Мал, амьтны халдварт өвчингүй, тайван бус, нутагт байгаа мал, амьтан өмчлөгч иргэн, хуулийн этгээд нь холбогдох заавар, зөвлөмжийн дагуу шинжилгээнд тогтмол хамруулах үүрэг хүлээнэ.

14.8.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори нь харьялах нутаг дэвсгэрийн хэмжээнд хийсэн тандалтын дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

15 дугаар зүйл.Халдварт өвчнийг оношлох, шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх

15.1.Мал, амьтанд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, тодорхой бус шалтгаанаар мал, амьтан хорогдсон тохиолдолд малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч, үзэсгэлэн, худалдаа, уралдаан, тэмцээнд ирсэн мал, амьтныг хариуцаж байгаа болон үхсэн, өвчний сэжиг илэрсэн малд үзлэг хийсэн малын эмч, мал, амьтан бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллагын удирдлага, гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, эсхүл мал эмнэлгийн тасагт 12 цагийн дотор мэдэгдэнэ.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан нөхцөл үүссэн үед малчин, амьтан маллагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

15.2.1.шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, ойролцоо малчдад мэдэгдэх;

15.2.2.энэ хуулийн 9.8.2-т заасан үүрэг хүлээх;

15.2.3.өвчний сэжигтэй мал, амьтныг сүргээс тусгаарлахад зориулан хашаа, байр бэлтгэх, тусгаарлан маллах, арчлах;

15.2.4.малын эмчийн заавар, зөвлөмжийг биелүүлэх.

15.3.Дуудлага хүлээн авсан гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

15.3.1.өвчний сэжиг илэрсэн хот айл, эрчимжсэн аж ахуйн бүх малд нэн даруй эрүүл мэндийн үзлэг хийж, тархвар зүйн байдлыг тодорхойлж, өвчний эмнэл зүйн шинж тэмдэг болон түргэн оношууруын дүнг үндэслэн анхны онош тогтоох;

15.3.2.халдварт өвчний сэжигтэй мал, амьтанд тусгайлсан тэмдэг тавьж хяналтад авах;

15.3.3.анхны оношийг баталгаажуулах зорилгоор зохих журам, зааврын дагуу сорьц авч 12 цагийн дотор мал эмнэлгийн тасагт хүргүүлэх;

15.3.4.өвчний тархалтын хүрээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлж, иргэдэд сээрэмжлүүлэг, зөвлөмж өгөх;

15.3.5.анхны онош болон хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мал эмнэлгийн тасагт нэн даруй мэдээллэх.

15.4.Халдварт өвчний анхны оношийн талаар мэдээлэл хүлээн авсан мал эмнэлгийн тасаг дараах үйл ажиллагааг нэн даруй хэрэгжүүлж, сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад мэдээлнэ:

15.4.1.анхны оношийн талаархи мэдээллийг 2 цагийн дотор дамжуулах;

15.4.2.хорио цээр, хязгаарлалт тогтоо шаардлагатай халдварт өвчин гарсан нь анхны оношоор тогтоогдсон бол тухайн нутаг дэвсгэрт байгаа айл өрх, мал, амьтны талаар судалгаа хийж, энэ хуулийн 16.1.1-16.1.3-т заасан бүсийн зураглал гаргах;

15.4.3.анхны онош тогтоогдсон хот айл, эрчимжсэн аж ахуйн байршлын солбицлыг тогтоох.

15.5.Хорио цээр, хязгаарлалт тогтоо халдварт өвчний талаар мэдээлэл хүлээн авсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах үйл ажиллагааг нэн даруй хэрэгжүүлнэ:

15.5.1.энэ хуулийн 17.2, 18.1, 18.3-т заасны дагуу дэглэм тогтоож, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах, хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, эсхүл хориглох;

15.5.2.энэ хуулийн 16.1.1-16.1.3-т заасан бус дэх мал, гэрийн тэжээвэр болон зэрлэг амьтны байршил, нягтаршил, хөдөлгөөнийг тандах ажиллагааг зохион байгуулах.

15.6.Халдварт өвчний анхны оношийн талаар мэдээлэл хүлээн авсан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

15.6.1.халдварт өвчнийг оношлох, түүнтэй тэмцэх чиглэлээр сум, дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөмжөөр хангах;

15.6.2.хорио цээр, хязгаарлалт тогтоо халдварт өвчний анхны оношийн талаархи мэдээллийг хүлээн авснаас хойш 2 цагийн дотор харьялах нутаг дэвсгэрийн холбогдох байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээлэх;

15.6.3.мал эмнэлгийн тасаг хүсэлт гаргасан тохиолдолд мэргэжлийн баг томилон ажиллуулах;

15.6.4.гоц халдварт өвчин гарсан үед тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаархи өдөр тутмын мэдээллээр мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бусад байгууллагыг хангах;

15.6.5.лабораторийн шинжилгээгээр халдварт өвчний анхны онош тогтоогдвол өвчний голомтыг устгах хариу арга хэмжээг холбогдох зааврын дагуу хэрэгжүүлэх.

15.7.Сорьц хүлээн авсан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

15.7.1.хүлээн авсан сорьцыг шинжилгээний аргын стандартад заасан хугацаанд багтаан шинжлэх, эсхүл хүлээн авснаас хойш 24 цагийн дотор улсын мал эмнэлгийн лабораторид хүргүүлэх;

15.7.2.халдварт өвчний анхны оношийн талаар 2 цагийн дотор аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад мэдээлэх.

15.8.Сорьц хүлээн авсан улсын мал эмнэлгийн лаборатори дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

15.8.1.сорьцод шинжилгээ хийж, дүгнэлтийг сорьц ирүүлсэн этгээд, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 2 цагийн дотор мэдээлэх;

15.8.2.энэ хуулийн 11.2-т заасан зааврын дагуу халдварт өвчний анхны онош тогтоогдоноос хойш ажлын таван өдөрт багтаан олон улсын лавлагaa лабораторийд сорьцыг илгээж, онош баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

15.8.3.аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори хүсэлт гаргасан тохиолдолд мэргэшсэн малын эмч томилон ажиллуулах.

15.9.Халдварт өвчний сэжиг илэрсэн, онош баталгаажсан тохиолдолд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

15.9.1.халдварт өвчнийг оношлох, түүнтэй тэмцэх чиглэлээр мал эмнэлгийн салбарын бүх шатны байгууллагын хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөмжөөр хангах, хяналт тавих;

15.9.2.гоц халдварт өвчний оношилгооны дүгнэлт, тархвар зүйн судалгаанд тулгуурлан тухайн өвчний голомтыг цомхотгох, устгах хариу арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх;

15.9.3.гоц халдварт өвчний анхны оношиг баталгаажсан тухай мэдээллийг хүлээн авснаас хойш 2 цагийн дотор Улсын онцгой комисст хүргүүлж, нийтэд мэдээлэх.

15.10.Халдварт өвчний сэжиг илэрсэн, эсхүл онош баталгаажсан тухай мэдээлэл илгээсэн, хүлээн авсан иргэн, байгууллага, албан тушаалтан тухайн цаг хугацаа, огноог тодорхой бичиж тэмдэглэнэ.

15.11.Мал, амьтны гоц халдварт өвчнийг яаралтай мэдээлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.12.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийд анхны онош тогтоо болон улсын мал эмнэлгийн лабораторийд онош тогтоо мал, амьтны халдварт өвчний жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

15.13.Энэ хуулийн 28.2-т заасан байгууллагын даргаас бусад этгээд гоц халдварт өвчний оношийн талаар нийтэд мэдээлэх, бусдад дамжуулахыг хориглоно.

16 дугаар зүйл.Халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний бүсчлэл

16.1.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоохдоо доор дурдсан бүсийн хилийн заагийг тодорхой заана:

16.1.1.өвчин гарсан эрчимжсэн аж ахуй, хот айлтай бэлчээр, ус давхцан нутаглаж байгаа хот айл, эрчимжсэн аж ахуйн бэлчээр, нутгийг хамруулан халдвартын голомтын бүс;

16.1.2.бэлчээр, ус тусгаар боловч халдвартын голомттой ойролцоо нутаглаж байгаа өвчиний халдвартархаж болзошгүй хот айл, эрчимжсэн аж ахуйн бэлчээр, нутгийг хамруулан сэжигтэй бүс;

16.1.3.улсын болон олон улсын чанартай авто зам, төмөр зам, мал тууврын зам, хүн, малын шилжилт хөдөлгөөний байдлыг харгалзан сэжигтэй бүсэд багтсан сумын хилийн цэсийн дагуух бэлчээр, нутгийг хамруулан хамгаалалтын бүс;

16.1.4.өвчиний халдварт дамжаагүй болох нь тархвар зүйн судалгаа, эмнэл зүйн үзлэг, шинжилгээгээр тогтоогдсон, сэжигтэй болон хамгаалалтын бүсийн заагаас гадна орших бэлчээр, нутгийг бүхэлд нь өвчингүй бүс;

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан бүсийн хилийн заагийг тогтоохдоо олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, бэлчээрийн мал аж ахуй эрхлэх онцлог, өвчин гарсан нутгийн газар зүйн байршил, дэд бутэц, хүн, мал, амьтны нягтаршил, халдвартын байдлыг харгалзана.

17 дугаар зүйл.Хорио цээрийн дэглэм тогтоох, цуцлах

17.1.Хорио цээрийн дэглэм тогтоох өвчиний жагсаалт, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

17.2.Хорио цээрийн дэглэм тогтоох өвчиний жагсаалтад багтсан халдварт өвчин гарсан үед доор дурдсан албан тушаалтан голомтын бүсийн хилийн зааг болон хорио цээрийн дэглэмийг тогтоож, цуцална:

17.2.1.халдварт өвчиний тархалт нэг сумын нутаг дэвсгэрийг хамарсан, эсхүл халдварт өвчиний голомтыг нэгтгэх нөхцөл үүссээгүй бол мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн сумын Засаг дарга;

17.2.2.хоёр буюу түүнээс дээш сумын нутгийг хамарсан халдварт өвчиний голомтыг нэгтгэх нөхцөл үүссэн бол аймгийн мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга;

17.2.3.халдварт өвчиний тархалт нийслэлийн нутаг дэвсгэрийг хамарсан бол харьялах мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн нийслэлийн Засаг дарга;

17.2.4.халдварт өвчиний тархалт төмөр зам, олон улсын нисэх буудал, хилийн боомт, хилээр дамжин өнгөрүүлэх цэгийг хамарсан, эсхүл хоёр буюу түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэр дэх голомтыг нэгтгэх нөхцөл үүссэн бол мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар.

17.3.Эмнэлгийн яаралтай тусламж авахаас бусад тохиолдолд хорио цээрийн дэглэм тогтоосон голомтын бүсээс гадагш гарах хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглоно.

18 дугаар зүйл.Хязгаарлалтын дэглэм тогтоох, цуцлах

18.1.Энэ хуулийн 17.2-т заасан этгээдийн шийдвэрээр хорио цээрийн дэглэмийг цуцалж, хязгаарлалтын дэглэмд шилжүүлнэ.

18.2.Хязгаарлалтын дэглэм тогтоох өвчиний жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.3.Хорио цээрийн дэглэм тогтоох өвчин гарсан болон хязгаарлалтын дэглэм тогтоох өвчиний жагсаалтад багтсан халдварт өвчин гарсан үед энэ хуулийн 16.1.1-16.1.3-т заасан бүсийн хилийн зааг, хязгаарлалтын дэглэмийг тогтоох, цуцлахдаа энэ хуулийн 17.2-т заасан зохицуулалтыг мөрдөнө.

18.4.Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсээс гарах мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглоно.

18.5.Зайлшгүй шаардлагаар гарах зорчигч тээврийн хэрэгсэл, хүний хувцас хэрэгслийг шалган нэвтрүүлэх цэг дээр халдвартгүйтгэл хийж гаргана.

19 дүгээр зүйл.Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах мэргэжлийн баг, ангийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

19.1.Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах мэргэжлийн багийг малын эмчээр ахлуулан тухайн сум, нийслэлийн Засаг дарга томилно.

19.2.Мэргэжлийн баг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

19.2.1.мал, амьтанд эмнэл зүйн үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээний сорьц авах, илгээх;

19.2.2.энэ хуулийн 16.1.4-т заасан бүсээс бусад бүсийн мэдрэмтгий мал, амьтныг дархлаажуулах;

19.2.3.өвчиний ил шинж тэмдэгтэй болон лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн мал, амьтанд ялан тэмдэглэгээ хийж, малчдад заавар, зөвлөгөө өгөх;

19.2.4.энэ хуулийн 16.1.1-д заасан бүс дэх хашаа, хороо, уст цэг, малын тоног хэрэгслийг халдвартгүйтгэх;

19.2.5.зайлшгүй шаардлагаар төхөөрсөн, устгасан мал, амьтны биологийн хаягдал, хүүр, сэг зэмийг устгах цэг тогтоох;

19.2.6.энэ хуулийн 19.3.2-т заасан шалган нэвтрүүлэх цэг, 19.2.5-д заасан устгалын цэгт хийгдсэн ариутгал, халдвартгүйтгэлийн тайланг сум, дүүргийн Засаг дарга, мал, эмнэлгийн тасагт хүргүүлэх;

19.2.7.мал эмнэлгийн тасгийг халдварт өвчний цагийн байдлын талаархи мэдээллээр хангах.

19.3.Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32.1.2-т заасны дагуу байгуулагдсан мэргэжлийн анги дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

19.3.1.энэ хуулийн 16.1.1-д заасан бүсийн хилийн зааг дээр таних тэмдэг байрлуулах, уг бүсийн хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглох;

19.3.2.энэ хуулийн 16.1.2, 16.1.3-т заасан бүсийн авто замын гол чиглэлд шалган нэвтрүүлэх цэг байгуулж, хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, хязгаарлах;

19.3.3.устгалын цэг байгуулах, хашаа, хамгаалалт барих, сээрэмжлүүлэх тэмдэг байрлуулах, энэ хуулийн 19.1-д заасан мэргэжлийн багийн ялан тэмдэглэсэн өвчтэй болон өвчний сэжигтэй мал, амьтныг эрх бүхий байгууллагаас баталсан зааврын дагуу устгах, эсхүл төхөөрөх;

19.3.4.энэ хуулийн 16.1.1-д заасан бүсэд оруулах хүнс, бараа, бусад зүйлийг тогтоосон цэгт тусгайлан бэлтгэсэн талбай /тавцан/-д буулгаж, сэлгүүлэн хүргүүлэх хэлбэрээр зохион байгуулах.

20 дугаар зүйл.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагаа

20.1.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт дараахь үйл ажиллагааг хориглоно:

20.1.1.энэ хуулийн 19.3.2-т заасны дагуу байгуулсан шалган нэвтрүүлэх цэгээс бусад газраар хүн, мал, тэжээвэр амьтан, тээврийн хэрэгсэл орох, гарах, дамжин өнгөрөх;

20.1.2.Гамшигаас хамгаалах тухай хуулийн 22.3-т заасан орон нутгийн онцгой комиссын зөвшөөрөлгүйгээр бэлчээр, нутаг сэлгэх;

20.1.3.нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, хүн, мал, амьтны бөөгнөрөл бий болгох;

20.1.4.мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, тээвэрлэх, худалдах;

20.1.5.халдварт өвчнөөр өвчилсөн мал, амьтан байрлаж байсан хашаа, байр, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг халдвартгүйтгэхээс өмнө дахин ашиглах.

21 дүгээр зүйл.Мал, амьтны шимэгчтэх өвчинтэй тэмцэх арга хэмжээ

21.1.Мал эмнэлгийн тасаг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран энэ хуулийн 8.1-д заасан тархвар зүйн судалгаа хийж, мал, амьтны шимэгчтэх өвчин /цаашид "шимигчтэх өвчин" гэх/-ийг тандах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

21.2.Сум, дүүргийн шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн 01 дүгээр сард багтаан батална.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч доор дурдсан үүрэг хүлээнэ:

21.3.1.энэ хуулийн 21.2-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан шимэгчтэх өвчинд мэдрэмтгий мал, амьтныг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс тогтоосон хугацаанд бэлэн байлгаж, бүрэн хамруулах;

21.3.2.энэ хуулийн 9.8.2-т заасан үүргийг биелүүлэх.

21.4.Шимэгчтэх өвчиний тархалт, халдварталтын байдал улсын эдийн засаг, нийтийн эрүүл мэндэд аюул учруулах хэмжээнд хүрсэн талаар мал эмнэлгийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын зөвлөмж болон энэ хуулийн 28.9-д заасан мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн тухайн өвчинтэй тэмцэх төлөвлөгөөг боловсруулж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжилтийг зохион байгуулна.

21.5.Шимэгчтэх өвчинийг тандах судалгааны хуудас болон шимэгчтэх өвчинтэй тэмцэх зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

21.6.Шимэгчтэх өвчинийг тандах судалгааны дүн, энэ хуулийн 21.2, 21.4-т заасан төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг мал эмнэлгийн тасаг нэгтгэж, дараа оны 01 дүгээр улиралд багтаан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад хүргүүлнэ.

22 дугаар зүйл.Мал, амьтны халдвартгүй өвчний оношилгоо, эмчилгээ

22.1.Мал эмнэлгийн тасаг энэ хуулийн 8.5-д заасан журмын дагуу цуглувансан мэдээллийг нэгтгэн тухайн нутаг дэвсгэрт бүртгэгдэж байгаа халдвартгүй өвчний анхдагч мэдээллийн сан бүрдүүлнэ.

22.2.Мал эмнэлгийн тасаг мал, амьтны халдвартгүй өвчний анхдагч мэдээллийг гамшгийн үед долоо хоног тутамд, тайван үед хагас жил тутамд аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад хүргүүлнэ.

22.3.Малчин, амьтан маллагч нь мал, амьтныг өдөр тутамд ажиглах, өвчилсөн, гэмтсэн үед анхны тусламж үзүүлж, сонгосон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид мэдэгдэнэ.

22.4.Энэ хуулийн 22.3-т заасан мал эмнэлгийн үйлчилгээний нэгж халдвартгүй өвчний оношиг эмнэл зүйн шинж тэмдэг,

шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн тогтоож, малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчийн зөвшөөрснөөр эмчилгээ хийнэ.

22.5.Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мал, амьтны халдвартгуй өвчин, тэдгээрийн эрсдэл, хор уршиг, сэргийлэх арга хэмжээний талаар харьялах нутаг дэвсгэрийн малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчид улирал тутам зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

22.6.Онош нь тодорхойгүй халдвартгуй өвчиний шалтгаан, хүн, мал, амьтны эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөг тогтоох, эмчилгээний аргыг боловсруулах зорилгоор захиалан гүйцэтгүүлсэн шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ**

23 дугаар зүйл.Мал, амьтнаас хүнд халдвартладаг өвчинтэй тэмцэх, хяналтад авах арга хэмжээ

23.1.Мал, амьтнаас хүнд халдвартладаг өвчин /цаашид "зооноз өвчин" гэх/-тэй тэмцэх, хяналтад авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд мал, амьтны өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаархи энэ хуулийн зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

23.2.Зооноз өвчинөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "хамтарсан зөвлөл" гэх/-ийг эрүүл мэндийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд байгуулж, ажиллах журмыг хамтран батална.

23.3.Зооноз өвчиний хяналтад авах стратеги төлөвлөгөөг эрүүл мэндийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга хамтран батална.

23.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга зооноз өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2-т заасны дагуу, энэ хуулийн 23.2-т заасан хамтарсан зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлнэ.

23.5.Зооноз өвчиний халдварт авах эрсдэл бүхий иргэдэд тухайн өвчиний талаар мэдлэг олгох сургалтыг мал эмнэлгийн болон эрүүл мэндийн бүх шатны байгууллага хамтран зохион байгуулна.

23.6.Хот, суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэх байршлыг тухайн шатны мал эмнэлгийн улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Засаг дарга тогтооно.

23.7.Энэ хуулийн 23.6-д заасан байршилд худалдаа эрхлэхэд тавигдаа мал эмнэлэл, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

24 дүгээр зүйл.Мал, амьтны эмийн зохистой хэрэглээг нэвтрүүлэх, хянах

24.1.Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

24.2.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь жоргүй олгохоор зөвшөөрөгдсөн эм хэрэглэхдээ малын эмчээс зөвлөгөө, зааварчилгаа авна.

24.3.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим сантай байна.

24.4.Мал эмнэлгийн улсын байцаагч мал, амьтны эмийн үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд хяналт тавьж, дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.4.1.мал, амьтны эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй, сорилт, баталгаажуулалт хийгдээгүй эмийг эгүүлэн татах, эсхүл угстах;

24.4.2.зөрчил гаргасан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоо, давтан гаргасан бол үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл цуцлах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

24.4.3.жороор олгох мал, амьтны эмийг дур мэдэн хэрэглэсэн бол тухайн хот айл, эрчимжсэн аж ахуйгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх эрхийг гурван сараар хязгаарлах.

25 дугаар зүйл.Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн хяналт

25.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал, амьтны тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх, улсын бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл олон улсын хэрэглээнээс хасагдсан тэжээлийн нэмэлтийг зах зээлээс эгүүлэн татах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

25.2.Мал, амьтны тэжээлийн нэмэлтийг бүртгэх, худалдаа, эгүүлэн татах, импортын зөвшөөрөл олгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25.3.Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар зохицуулна.

26 дугаар зүйл.Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх эм, пестицидийн үлдэгдлийн хяналт

26.1.Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд дэх эм, пестицидийн үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө Засгийн газарт танилцуулж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

26.2.Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд дэх эм, пестицидийн үлдэгдлийн хяналтын төлөвлөгөөг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

26.3.Малын эмч, эсхүл малчин мал, амьтны эмчилгээнд хэрэглэсэн эмийн нэр, огноо, хэрэглэсэн тун, хэмжээний талаархи мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн бүртгэлийн дэвтэрт тухай бүр тэмдэглэж, баримтжуулна.

26.4.Мал, амьтны эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

26.5.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм худалдан авах, хэрэглэхийг хориглоно.

27 дугаар зүйл.Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнд ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгаажуулах

27.1.Нийтийн хэрэгцээний зориулалтаар мал төхөөрөх цэг, үйлдвэрт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

27.1.1.гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь байр, орчинд халдвартгүйтгэл хийх, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангуулах;

27.1.2.мал эмнэлгийн улсын байцаагч нь мал төхөөрөхийн өмнөх болон дараах үзлэг хийх.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан үйл ажиллагааны үр дүн, 7.4.2-т заасан баримт нотолгоог үндэслэн үзлэг хийсэн албан тушаалтан түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгоно.

27.3.Энэ хуулийн 29.1, 29.3-т заасан лаборатори түүхий мах, өндөг, сүүний үзүүлэлтийг стандартад заасан аргачлалын дагуу шинжилж тогтооно.

27.4.Иргэн, хуулийн этгээд хадгалалт, тээвэрлэлтийн явцад мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гадна байдалд өөрчлөлт орж, шинэлэг байдлаа алдсан, эсхүл бохирдсон бол худалдахаас өмнө лабораторийн магадлан шинжилгээ хийлгэнэ.

27.5.Магадлан шинжилгээгээр эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан нь тогтоогдвол мал, амьтны гаралтай хүнсний түүхий эдэд шинжилгээ хийсэн лаборатори магадлан шинжилгээний гэрчилгээ олгоно.

27.6.Энэ хуулийн 27.2, 27.5-д заасан гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

27.7.Хяналтын цэгийн улсын байцаагч энэ хуулийн 27.2-т заасан гэрчилгээгүй тээвэрлэсэн мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнийг 14 хүртэл хоног саатуулж, мал эмнэлгийн хяналтын цэгт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

27.7.1.тээвэрлэж байгаа түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлгийн хяналтын цэгт тусгайлан бэлтгэсэн агуулах, саравч, тавцанд буулагах мэдэгдэл өгөх;

27.7.2.нарийвчилсан үзлэг хийж, шаардлагатай гэж үзвэл сорьц авч мал эмнэлгийн лабораторид хүргүүлэх;

27.7.3.үзлэгийн дүн, лабораторийн магадлан шинжилгээний дүгнэлтээр эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан нь тогтоогдвол мал эмнэлгийн гэрчилгээ олгох;

27.7.4.эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй нь лабораторийн магадлан шинжилгээний дүгнэлтээр тогтоогдсон бол түүхий эд, бүтээгдэхүүн болон сав, баглаа боодол, хог, хаягдлыг зааврын дагуу мэргэжлийн байгууллагаар устгуулах;

27.7.5.тээврийн хэрэгсэл, тээвэрлэлтэд хэрэглэсэн тоног төхөөрөмжийг халдвартгүйтгэх.

27.8.Энэ хуулийн 27.7-д заасан хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зардлыг тухайн мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэгч иргэн, хуулийн этгээд хариуцна.

27.9.Энэ хуулийн 27.7.2-т заасан сорьц хүлээн авсан лаборатори долоо хоногт багтаан шинжилгээ хийж, дүгнэлтээ сорьц ирүүлсэн хяналтын цэгийн улсын байцаагчид хүргүүлнэ.

27.10.Мал, амьтны гаралтай хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.2 дахь заалтыг дагаж мөрдөнө.

27.11.Үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлэх, худалдах үед мөрдөх эрүүл ахуй, ариун цэврийн зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

27.12.Энэ хуулийн 27.1.2-т заасан үзлэг, шинжилгээгээр халдварт өвчний сэжиг илэрвэл сорьц авч лабораторид хүргүүлэх бөгөөд харьяалах мал эмнэлгийн тасагт нэн даруй мэдэгдэнэ.

27.13.Мэдээлэл хүлээн авсан мал эмнэлгийн тасаг энэ хуулийн 15.4-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

27.14.Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27.15.Хэрэглэгч нь Хүнсний тухай хуулийн 15 дугаар зүйлд заасанаас гадна мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дараах оролцоогоор дэмжинэ:

27.15.1.эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй худалдааны төв, хүнсний дэлгүүр, битүүмжлэлгүй, хөргүүргүй тээврийн хэрэгсэл, зах, лангуу, муҳлаг болон ил задгай газар худалдаалагдаж байгаа мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдаж авахгүй байх;

27.15.2.энэ хуулийн 27.2, 27.5, 27.7.3-т заасан гэрчилгээгүй бүтээгдэхүүн худалдан авах, тээвэрлэх, зөөвөрлөхгүй байх;

27.15.3.энэ хуулийн 27.15.1, 27.15.2-т заасан зөрчлийн талаар харьяалах мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, холбогдох байгууллагад нэн даруй мэдээлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ **МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО**

28 дугаар зүйл.Мал эмнэлгийн салбарын байгууллага

28.1.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь улсын хэмжээнд мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ.

28.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, хүн амыг зооноз өвчний эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавина.

28.3.Энэ хуулийн 28.2-т заасан байгууллага харьландаа мал эмнэлгийн судалгаа, шинжилгээ, оношилгоо, эрүүл ахуй, ариун цэвэр, сорилт, баталгаажуулалтын лаборатори ажиллуулж болно.

28.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага нь мал эмнэлгийн салбарын бүх шатны байгууллага, лаборатори, мал эмнэлгийн тасаг болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөмжкөөр хангаж ажиллана.

28.5.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага нь мал эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, худалдааны чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажиллана.

28.6.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагын дарга бөгөөд ерөнхий малын эмч нь мал эмнэл зүйн чиглэлээр магистраас доошгүй боловсролын зэрэгтэй, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан малын эмч байна.

28.7.Мал эмнэлгийн бүх шатны төрийн байгууллагын удирдах албан тушаалтныг доор дурдсанаар томилж, чөлөөлнө:

28.7.1.мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагын даргыг Засгийн газар;

28.7.2.энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагын дарга;

28.7.3.мал эмнэлгийн тасгийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын дарга.

28.8.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мал эмнэлгийн тасгийн бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын бүтцийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагын дарга батална.

28.9.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагын дэргэд мал, амьтны эрүүл мэндийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл ажиллана.

28.10.Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.11.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагын дэргэд мал, амьтны эмийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хянах үүрэг бүхий орон тооны бус малын эмийн салбар зөвлөл, фармакопейн хороо ажиллана.

28.12.Малын эмийн салбар зөвлөл болон фармакопейн хороог мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий ажилтан мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагад ажиллана.

28.13.Малын эмийн салбар зөвлөл болон фармакопейн хорооны ажиллах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн

Засгийн газрын гишүүн батална.

29 дүгээр зүйл.Мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаа

29.1.Улсын мал эмнэлгийн лаборатори дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

29.1.1.итгэмжлэлийн хүрээнд мал, амьтны өвчин, хордлогыг оношлох, тандах, аймаг, нийслэл, сум, дүүргийн лабораторийн шинжилгээний дүнг баталгаажуулах, сүлжээ байдлаар ажиллах;

29.1.2.Хүнсний бүтээгдхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2, 15.3-т заасан мал, амьтны эрүүл мэндийн салбарт хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэх;

29.1.3.лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, нийтэд зориулсан мэдээллийг цахим хуудаст байршуулах.

29.2.Малын эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

29.2.1.мал эмнэлгийн зориулалтаар шинээр зохион бүтээсэн, үйлдвэрлэсэн, импортолсон эм, эмийн түүхий эдэд сорилт, туршилт, шинжилгээ хийх, чанарыг баталгаажуулах;

29.2.2.мал, амьтны эм, эмийн түүхий эдэд сорилтын лабораторийн дүгнэлт гаргах.

29.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлгийн лаборатори харьялах нутаг дэвсгэртээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

29.3.1.итгэмжлэлийн хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээ хийх, мал, амьтны өвчний оношлох;

29.3.2.дээд шатны лабораториос ирүүлсэн захиалгын дагуу сорьц авах, илгээх;

29.3.3.шинжилгээний дүнгээр мэдээллийн сан бүрдүүлж дээд шатны лабораторид хүргүүлэх.

29.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам, мал эмнэлгийн үндэсний лавлагaa лабораторийг сонгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30 дугаар зүйл.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаа

30.1.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл бүхий малын эмчтэй, стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмжтэй, мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд байна.

30.2.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйлчилгээний хүрээнээс хамаарч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

30.2.1.бүх төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ эрхлэх бол ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний;

30.2.2.тодорхой төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, тухайн төрлийн мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ эрхлэх бол төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний;

30.2.3.мал эмнэлгийн тодорхой мэргэшлээр дагнан явуулын болон суурин үйлчилгээ үзүүлэх бол тусгай мэргэшлийн тусламж, үйлчилгээний.

30.3.Энэ хуулийн 30.2-т заасан мал эмнэлгийн үйлчилгээний төрөл тус бүрээр үйл ажиллагааны стандартыг стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

30.4.Итгэмжлэлтэй малын эмч дангаараа, эсхүл итгэмжлэлтэй малын эмчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан хуулийн этгээд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулж, харьялах аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлснээр мэргэжлийн үйлчилгээ эрхлэх эрхтэй болно.

30.5.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага шинээр байгуулах болон шинэчлэн зохион байгуулагдаж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг бүртгэхдээ дараахь бичиг баримтыг үндэслэнэ:

30.5.1.энэ хуулийн 30.2.1-д заасан нэгжид ажиллах итгэмжлэлтэй малын эмч тухайн сумын байнгын оршин суугч болохыг нотолсон Засаг даргын тодорхойлолт;

30.5.2.үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө;

30.5.3.энэ хуулийн 30.3-т заасан холбогдох стандартыг хангасан талаар харьялах мал эмнэлгийн тасгийн дүгнэлт гаргуулсан байх.

30.6.Энэ хуулийн 30.2.3-т заасан үйл ажиллагааны чиглэлээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулах тохиолдолд энэ хуулийн 30.5.1 дэх заалт, 30.9 дэх хэсэг хамаарахгүй.

30.7.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг бүртгүүлэх хүсэлт хүлээн авснаас хойш ажлын таван өдөрт багтаан шийдвэрлэнэ.

30.8.Хүсэлт гаргасан этгээд энэ хуулийн 30.5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтыг үнэн зөв, бүрэн ирүүлсэн бол аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага бүртгэхээс татгалзах эрхгүй.

30.9.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж өөрийн байршиж байгаа сум, дүүргийн нутаг дэвсгэрээс өөр нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээ үзүүлэх мал эмнэлгийн тасагт хүсэлтээ илэрхийлж, бүртгүүлнэ.

30.10.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч тухайн нутаг дэвсгэрт байнга болон түр хугацаагаар үйлчилгээ үзүүлж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өөрөө сонгон үйлчлүүлэх эрхтэй.

30.11.Боловсролын байгууллага болон бусад хуулийн этгээдийн харьяанд сургалтын зориулалттай үйл ажиллагаа эрхэлдэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж энэ хуулийн 30.7-д зааснаар бүртгүүлээгүй бол нийтэд үйлчлэх эрхгүй.

30.12.Сум, дүүргийн Засаг дарга, мал эмнэлгийн тасаг, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж энэ хуулийн 28.2-т заасан байгууллагын даргын баталсан загварын дагуу гурвалсан гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлнэ.

30.13.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

30.13.1.мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох стандарт, техникийн зохицуулалт, журам, зааврыг дагаж мөрдөх;

30.13.2.мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах;

30.13.3.мал эмнэлгийн үйлчилгээний тайлан, мэдээг хууль тогтоомжид заасан хугацаанд гаргаж, мал эмнэлгийн тасагт хүргүүлэх.

30.14.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн талаархи мэдээллийн сан бүрдүүлж, жил бүр шинэчлэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан териийн захирагааны байгууллагад хүргүүлнэ.

30.15.Мал эмнэлгийн үйлчилгээний технологийн мөрдөлтөд мал эмнэлгийн тасаг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр хяналт тавьж, тайланг хагас жил тутам аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад хүргүүлнэ.

30.16.Хяналт, шалгалтын үр дүн, зөрчлийн талаархи мэдээллийг үйлчлүүлэгчид хүргэх ажлыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага харьяалах мал эмнэлгийн тасагтай хамтран зохион байгуулна.

30.17.Дараахь тохиолдолд аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг бүртгэлээс хасаж, энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ:

30.17.1.энэ хуулийн 30.5-д заасан шаардлагыг бүрэн хангахгүй болсон;

30.17.2.мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхдээ гэрээний биелэлттэй холбоотой зөрчлийг давтан гаргасныг мал эмнэлгийн тасаг тогтоосон;

30.17.3.хоёроос дээш жил мал эмнэлгийн үйлчилгээ эрхлээгүй.

30.18.Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.19.Малын эмчийн мэргэжилтэй гадаадын иргэнийг тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр итгэмжлэлтэй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж гэрээгээр ажиллуулж болно.

30.20.Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам, малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.21.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид ажиллах техникийн ажилтан нь мэргэжлийн үнэмлэхтэй байх бөгөөд мал, амьтны өвчинеэс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд малын эмчийн удирдамж, зааврын дагуу оролцно.

30.22.Мал эмнэлгийн техникийн ажилтан бие даасан үйл ажиллагаа явуулах эрхгүй.

30.23.Энэ хуулийн 28.2-т заасан байгууллага мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээний норматив тогтоох, малын эмч, мал эмнэлгийн техникийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, малын эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах эрхтэй.

31 дүгээр зүйл.Мал эмнэлгийн хяналт

31.1.Мал эмнэлгийн төрийн хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага, тэдгээрийн улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагч, гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагч хэрэгжүүлнэ.

Энэ хэсэгт 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

31.2.Мал эмнэлгийн улсын байцаагч бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй малын эмч байна.

31.3.Энэ хуулийн 31.1-д заасан байгууллага, албан тушаалтан мал эмнэлгийн төрийн хяналтын чиглэлээр дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.3.1.мал эмнэлгийн байгууллагын мал эмнэлгийн гэрчилгээг үндэслэн гаалийн байгууллага экспорт, импортын гэрчилгээ, импортын болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдэл олгох;

/Энэ заалтад 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

31.3.2.мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх, мал, амьтны эм, тэжээл, тэжээлийн нэмэлт, мал эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, худалдах үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

31.3.3.мал, амьтны эм, мал эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, экспортлох, импортлох тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлэх.

31.4.Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг улсын хэмжээнд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага, аймаг, нийслэлд тухайн шатны мал эмнэлгийн байгууллага, сум, дүүрэгт мал эмнэлгийн улсын байцаагч хэрэгжүүлнэ.

31.5.Монгол Улсын хилээр нэвтрүүлэх мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь эрүүл мэндийн болон эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг улсын хэмжээнд мал эмнэлгийн салбарын ерөнхий байцаагч, аймаг, нийслэлд салбарын ерөнхий байцаагчийн зөвшөөрснөөр мал эмнэлгийн улсын ахлах байцаагч, улсын байцаагч баталгаажуулан олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгоно.

31.6.Энэ хуулийн 31.4-т заасан албан тушаалтан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.6.1.мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтныг зах зээлд нийлүүлэхийг хориглох, хорио цээрийн хяналтад оруулах, шаардлагатай тохиолдолд устгах;

31.6.2.мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй малын гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд зах зээлд нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг таслан зогсоох, шаардлагатай тохиолдолд татан авч халдвартгүйтгэх, эсхүл устгах;

31.6.3.малын эмчийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлэх.

31.7.Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналттай холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна.

32 дугаар зүйл.Малын эмч, мал эмнэлгийн ажилтны нийгмийн баталгаа

32.1.Малын эмч, мал эмнэлгийн техникийн ажилтан нь дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

32.1.1.мал эмнэлгийн байгууллагад мэргэжлээрээ таваас дээш жил ажиллаж байгаа малын эмчийг таван жил тутам мэргэжил дээшлүүлэх сургалтад улсын зардлаар хамруулах;

32.1.2.сум, дүүргийн мал эмнэлгийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа бол жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд ажил олгогчийн зардлаар хамруулах;

32.1.3.шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчний голомтод ажиллаж халдвэр авсны улмаас, эсхүл албан үүргээ гүйцэтгэх үедээ амь наасаа алдсан тохиолдолд түүний ар гэрт 36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг төрөөс олгох;

32.1.4.мал, амьтны гоц халдварт өвчний голомтод, энэ хуулийн 19.1, 19.3-т заасан мэргэжлийн баг, ангийн бүрэлдэхүүнд дайчлагдан ажиллах бол хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээр хангах, томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж дайчилгааг зохион байгуулсан байгууллагаас олгох;

32.1.5.сумын мал эмнэлгийн тасагт ажиллаж байгаа малын эмчид таван жил тутам нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг төрөөс олгох.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

33 дугаар зүйл.Улсын төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ

33.1.Мал эмнэлгийн үйлчилгээний дараах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

33.1.1.энэ хуулийн 7.14-т заасан хяналтын цгийн үйл ажиллагааны зардал;

33.1.2.энэ хуулийн 11.1.1-д заасан жагсаалтад орсон халдварт өвчинтэй тэмцэх, устгах арга хэмжээний зардал:

33.1.2.1.вакцин, оношуур, халдвартгүйтгэлийн бэлдмэл, хамгаалах хувцас, хэрэгслийн үнэ;

33.1.2.2.тандалт, судалгаа, лабораторийн шинжилгээ, дархлаажуулалт хийх, мэдээллийн сан бүрдүүлж ажиллуулах үйл ажиллагааны зардал;

33.1.2.3.эмнэл зүйн үзлэг, тарилга, халдвартгүйтгэл хийх, лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авах болон мал эмнэлгийн бусад үйлчилгээний хөлс;

33.1.2.4.зайлшгүй шаардлагаар төхөөрсөн малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 40 хувь, гоц халдварт өвчний улмаас зайлшгүй шаардлагаар устгасан малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 90 хувьтай тэнцэх нөхөн төлбөр.

33.1.3.халдварт болон шимэгчтэх өвчнийг тандах, эрт илрүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зардал, эмнэл зүйн үзлэг хийх, лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авах үйлчилгээний хөлс, оношлуурын үнэ:

33.1.3.1.шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчин;

33.1.3.2.энэ хуулийн 21.4-т заасан шимэгчтэх өвчин.

33.1.4.эмийн сорилт хийхэд ашиглагдах омог сэргээх, энэ хуулийн 4.1.13-т заасны дагуу ийлдсийн сан бүрдүүлэх, тэдгээрийг хадгалах, ашиглахад шаардагдах зардал;

33.1.5.гоц халдварт өвчин гарсан үед энэ хуулийн 19.1, 19.3-т заасны дагуу байгуулагдсан мэргэжлийн баг, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд дайчлагдан ажилласан малын эмч, мэргэжилтэн, албан хаагч, иргэдэл олгох дараахь зардал:

33.1.5.1.ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлсэн томилолтын зардал;

33.1.5.2.албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсан иргэний ар гэрт олгох 36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж.

33.2.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив, улсын төсөөвт байгууллагатай шууд гэрээ байгуулах хэлбэрээр эм, худалдан авах үнэ тарифыг төсөв, санхүүгийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

33.3.Энэ хуулийн 33.1.2.4, 34.2.2.2-т заасан нөхөн төлбөр олгоход баримтлах жишиг үнийг статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

33.4.Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн арга хэмжээний эдийн засгийн үр ашгийг тооцох судалгааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийнэ.

33.5.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага доор дурдсан үйл ажиллагааны санхүүжилтийг дараахь төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэнэ:

33.5.1.энэ хуулийн 23.3-т заасан стратеги төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай;

33.5.2.энэ хуулийн 15.5.2-т заасны дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай.

34 дугээр зүйл.Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ

34.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн санхүүжилтээр дараа онд хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээний төлөвлөгөөний төслийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мал эмнэлгийн тасаг боловсруулж, жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.

34.2.Мал эмнэлгийн үйлчилгээний дараахь зардлыг аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ:

34.2.1.энэ хуулийн 13.4-т заасан дэд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал;

34.2.2.энэ хуулийн 11.1.2-т заасан жагсаалтад орсон халдварт өвчинтэй тэмцэх, устгах арга хэмжээний дараахь зардал:

34.2.2.1.энэ хуулийн 33.1.2.1-33.1.2.3-т заасан зардал;

34.2.2.2.зайлшгүй шаардлагаар төхөөрсөн малын тухайн орон нутаг дахь жишиг үнийн 40 хувьтай тэнцэх нөхөн төлбөр.

34.2.3.хорио цээрийн дэглэм тогтоох өвчиний жагсаалтад орсон гоц халдварт өвчинөөс бусад халдварт өвчин гарсан үед тухайн шатны Засаг даргын шийдвэрээр хэрэгжүүлж байгаа голомтыг устгах, хяналтад авах арга хэмжээний зардал;

34.2.4.харьяалах нутаг дэвсгэрийн мал, амьтныг эрүүлжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал.

34.3.Мал эмнэлгийн үйлчилгээний дараахь зардлыг сум, дүүргийн төсвөөс санхүүжүүлнэ:

34.3.1.энэ хуулийн 13.4-т заасан дэд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал;

34.3.2.дуудлагын дагуу анхны онош тогтоох үйл ажиллагааны тээвэр, шатахууны зардал, халдварт өвчин гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах халдвартгүйтгэлийн бэлдмэлийн үнэ;

34.3.3.харьяалах нутаг дэвсгэрийн мал, амьтныг эрүүлжүүлэх зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал.

34.4.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүйг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тогтоосон бол энэ хуулийн 33.1.2.4, 34.2.2.2-т заасан нөхөн төлбөрийг олгохгүй.

35 дугаар зүйл.Иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэх арга хэмжээ

35.1.Мал эмнэлгийн үйлчилгээтэй холбогдсон дараахь зардлыг иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлнэ:

35.1.1.амьтны хүрээлэнгийн, циркийн, лабораторийн болон тэжээвэр амьтны эрүүл мэндийг хамгаалахад шаардагдах мал эмнэлгийн үйлчилгээний бүх зардал;

35.1.2.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх арга хэмжээний улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зааснаас бусад зардал;

35.1.3.шимэгчтэх өвчинтэй тэмцэх, эрүүлжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа энэ хуулийн 33.1.3.2, 34.2.4, 34.3.1-д зааснаас бусад арга хэмжээний зардал;

35.1.4.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх үйлчилгээний энэ хуулийн 22.6-д зааснаас бусад бүх зардал;

35.1.5.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг баталгаажуулахтай холбогдсон бүх зардал;

35.1.6.холбогдох хууль, тогтоомжид заасан бусад зардал.

ДОЛДУГААР БҮЛЭГ
БУСАД

36 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

36.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

36.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

37 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

37.1.Энэ хуулийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД